

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв



МЕНЕЖМЕНТИЙН СИМУЛЯЦИ

(Бизнесийн ахисан түвшний сургалт)

2026.9.1-3, 9.7-8

2026 он

1) Сургалтын танилцуулга:

Энэхүү сургалтаар компанийн менежментийн ерөнхий зураглалыг япон компаниудын шилдэг туршлагад тулгуурлан судлахын зэрэгцээ, орчин үеийн менежментийн симуляци (тусгайлан хөгжүүлсэн программ дээр бодит нөхцөлийг загварчлан тооцоолох) тоглоомоор дамжуулан практик дээр мэдлэгээ гүнзгийрүүлэх болно.

Монгол Улсын зах зээлийн эдийн засаг хөгжихийн хэрээр одоогийн болон шинээр байгуулагдсан компаниудын үйл ажиллагаа улс орны эдийн засаг, аж үйлдвэрийг хөгжүүлэхэд улам бүр чухал үүрэг гүйцэтгэж байна. Энэхүү нөхцөл байдалд, ардчилсан зах зээлийн эдийн засгийн тогтолцооны хүрээнд, компанийн үүсэн байгуулагдсанаас эхлэн хөгжиж төлөвших хүртэлх бүх үйл явцыг “ХҮН, ЭД ХӨРӨНГӨ, МӨНГӨ” гэсэн гурван гол хүчин зүйлийн үүднээс цогцоор нь ойлгох шаардлагатай юм. Мөн энэ чухал ойлголтыг бизнесийн практикт хэрэгжүүлэх эрэлт хэрэгцээ нэмэгдэж байна.

Компанийн менежментийн гол зарчмуудыг ойлгосноор бизнест амжилт гаргаж, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхээс гадна, ажилтнуудын ур чадварыг дээшлүүлж, тэдний ажиллах урам зоригийг ч мөн нэмэгдүүлж чадна.

Хүлээгдэх үр дүн:

- Компанийн удирдах түвшний болон ахлах ажилтнууд Японы компаниудын менежментийн шилдэг туршлагад суурилан бизнесийн ерөнхий зураглалыг судалж, менежментийн симуляци (тусгайлан хөгжүүлсэн программын дээр бодит нөхцөлийг загварчлан тооцоолох) тоглоомд оролцох замаар бодитоор бизнест хэрэглэх ур чадварыг эзэмшинэ.
- Тодруулбал, оролцогчид стратегич сэтгэлгээг олж авахын зэрэгцээ, маркетинг, санхүү, үйл ажиллагааны менежмент, хүний нөөцийн менежмент зэрэг салбаруудын нэгдсэн суурь мэдлэг болон практик ур чадварыг эзэмших болно.

2) Хугацаа: 2026.9.1-3, 9.7-8 (Даваа-Баасан, 15:00-19:30)

3) Хамрагдах хүн: Бизнесээ дараагийн түвшинд гаргахаар зорьж буй компанийн захирлууд, удирдах ажилтнууд

4) Хамрагдах хүний тоо: 30 хүн

※Хүний тоо гүйцсэн тохиолдолд хугацаанаас өмнө бүртгэл дуусахыг анхаарна уу!

5) Сургалтын төлбөр: 480,000 төгрөг

6) Хичээл заах багш: Сато Кацүхиро (Ph.D)



Васэда Их Сургуулийн Бизнесийн Сургуулийн профессор

Кэйо Их Сургуулийн Хуулийн Факультетийг төгссөн. Станфордын Их Сургуулийн магистрын зэрэгтэй. Киотогийн Их Сургуулийн Бизнесийн Удирдлагын дээд сургуульд докторын зэрэг хамгаалсан (Доктор, Менежментийн Шинжлэх Ухаан).

Япон улсын Хөгжлийн Банк (одоогийн Япон Улсын Хөрөнгө Оруулалтын Банк) болон МакКинзи & Компанийн түнш зэрэг албан тушаалд ажиллаж байсан. Түүний бичсэн “Практик стратеги болох компанийн үнэлэмж” (Даймонд Хэвлэлийн газар, 2023 оны 6-р сар)

Хичээл заах багш: Сүдо Шо (MBA)



“Сүкорэ” ХК-ийн ТУЗ-ийн дарга

LINE корпорацид интернэт сурталчилгааны газрын захирлаар ажиллаж, бизнес болон багийн удирдлагад ажилласан туршлагатай. Үүний дараа Дижитал Агентлагт төрийн байгууллагуудын дижитал шилжилтийг хариуцан ажилласан.

2021 онд “Сүкорэ” компанийг үүсгэн байгуулж, одоогийн байдлаар хувийн болон дээд боловсролын байгууллагуудын дараагийн үеийн удирдагчдыг бэлтгэхэд дэмжлэг үзүүлж байна.

Васэда Их Сургуулийн Бизнесийн Сургуулийг төгссөн.

Энэтхэгийн Бизнесийн Удирдлагын Их Сургууль, Бангалорт



Багш: Абико Жүнъя

LINE корпорацид бизнес хөгжүүлэлт, борлуулалт, харилцагчийн үйлчилгээний чиглэлээс эхлэн, онлайн болон жижиг дунд бизнест чиглэсэн зар сурталчилгааны бизнесийн баг байгуулж, өсөлтийн үе шат хүртэл удирдсан.

Ахлах менежерийн хувьд үйл ажиллагааг удирдан, бүтээгдэхүүний стратеги болон багийн бүтцийг бүхэлд нь хариуцан ажиллаж. Тэгээс эхлэн жилд 10 тэрбум иенээс дээш эргэлттэй бизнес болгон хөгжүүлсэн.

2026 онд Сколе ХК-д ажиллаж эхлэн, гүйцэтгэх захирал — бизнес хөгжүүлэлтийн газрын дарга албан тушаалд томилогдож. Үйлчилгээний бизнес хөгжүүлэлтийг удирдахын зэрэгцээ, багшийн хувьд мэдлэг туршлагаа системчлэх, шинэ үеийн боловсон хүчнийг бэлтгэх ажилд оролцож байна.

Доккёо их сургуулийн Гадаад хэлний факультетыг төгсөж, Токиогийн их сургуулийн Мэдээллийн технологийн магистрын хөтөлбөрийг дүүргэсэн.

7) Сургалтын хөтөлбөр:

Өдөр	Ак.цаг	Сэдэв	Агуулга	Цагийн хуваарь
9 сарын 1 /Даваа/	1	Танилцуулга: Компанийн менежментийг цогцоор нь харах (Багш: Сато)	- Сургалтын ерөнхий танилцуулга - Оролцогчид өөрийгөө танилцуулах	Хичээлийн цаг 15:00-19:30 Завсарлага 16:20-16:30 /10 мин/ 17:50-18:10 /20 мин/
	2	Компанийн менежментийн цогц дүр зураг (Багш: Сато)	Компанийн менежмент талаар Японы туршлагаас (Бизнесийн стратеги, Маркетинг)	
	3		Японы нэгэн компанийн Монголд бизнесээ эхлүүлсэн түүх, Монголын зах зээлд огт байхгүйгээс эхлэн хөгжүүлсэн туршлагаас суралцах багийн ажил ①	
9 сарын 2 /Мягмар/	4	Компанийн менежментийн гол зарчмууд (Багш: Сато)	Компанийн менежмент талаар Японы туршлагаас (Үйл ажиллагаа, бүтэц, хүний нөөц, санхүү)	
	5		Японы нэгэн компанийн Монголд бизнесээ эхлүүлсэн түүх, Монголын зах зээлд огт байхгүйгээс эхлэн хөгжүүлсэн туршлагаас суралцах багийн ажил ②	
	6		Японы нэгэн компанийн Монголд бизнесээ эхлүүлсэн түүх, Монголын зах зээлд огт байхгүйгээс эхлэн хөгжүүлсэн туршлагаас суралцах багийн ажил ③	
9 сарын 3 /Лхагва/	7	Компанийн менежментийн гол зарчмууд (Багш: Сато)	- Багийн илтгэл ① - Багийн илтгэл ②	
	8	Илтгэл, асуулт хариулт	- Нэгдсэн дүгнэлт - Асуулт хариулт, үнэлгээ	
9 сарын 7 /Даваа/	10	Танилцуулга: Менежментийн семуляци (Багш: Сүдо)	- Оролцогчид өөрийгөө танилцуулах - Компанийн үүсэл (Менежментийн симуляци)	
	11	Компанийн менежментийг практик, санхүүгийн талаас нь судлах (Багш: Сүдо)	- Практик менежмент (Анхны жил, 1-р улирал – Анхны жил, 3-р улирал) - Санхүүгийн тайланг ашиглан бизнест тоон шинжилгээ хийх	
	12		- Онолын менежмент (Анхны жил, 4-р улирал – 2 дахь жил, 2-р улирал) - Ашигт ажиллагааг үнэлэх, сайжруулах	
9 сарын 8 /Баасан/	13	Компанийн менежментийг практик, стратегийн талаас нь судлах (Багш: Сүдо)	- Практик менежмент (2 дахь жил, 3-р улирал – 2 дахь жил, 4-р улирал) - Өрсөлдөхүйц бизнесийн стратеги боловсруулах	
	14		- Практик менежмент (3 дахь жил, 1-р улирал – 3 дахь жил, 2-р улирал) - product out болон Market in	
	15		- Практик менежмент (3 дахь жил, 3-р улирал – 3 дахь жил, 4-р улирал) - Менежментийн үзүүлэлтийн шинжилгээ, үнэлгээ	

8) Гэрчилгээ: Сургалтдаа ирц бүрэн хамрагдсан оролцогчдод гэрчилгээ олгоно.

9) Бүртгэл: Доорх QR кодыг уншуулж бүртгүүлнэ үү.



10) Холбоо барих:



Утас: 7511-0879(Ext.3) , 8063-0879
Э-Мэйл: business@japan-center.edu.mn



Цахим хуудас: www.japan-center.edu.mn



Фейсбүүк хуудас: www.facebook.com/Mojc.business